

# Бэлэвсэн эмэгтэйн хоёр денар

-The Widow's Offering-



97Page

**Тайлбарлагч** Нэгэн өдөр, Есүс дагалдагч нартайгаа хамт сүмд очсон. Тэгээд хүмүүсийн өргөл өргөж байгааг ажиглан харж суув. Олон хүн дундаас нэг баян урд гарч ирлээ.

**Баян** Ёох, их хүнд байх чинь...

**Тайлбарлагч** Баян түүрүүчээ нээн олон хүний нүдэн дээр их мөнгөө гайхуулан харуулав. Тэр дундаас хэдийг сугалан өргөлийн хайрцаганд хийчихэв. Хүмүүс их мөнгө өргөж байгаа баяныг харан шивэр авир хийцгээлээ.

**Хүн-1** Хүүе, хүүе, тэр хүнийг харсан уу? Их баян юмаа.

**Хүн-2** Тэгэж их мөнгө өргөж байхыг харвал үнэхээр баян байхаа.

**Хүн-1** Харин тийм, мөнгө их өргөсөн юм чинь Бурхан түүнийг ихээр ерөөх байхдаа.



98Page

**Тайлбарлагч** Баяныг явсаны дараагаар ядруухан хувцасласан нэгэн ядуу эмэгтэй өргөл өргөхөөр ирэв. Эргэн тойронд нь олон хүн байсан боловч хэн ч түүнийг тоож харсангүй гэнэ.

**Эмэгтэй** Надад байгаа нь энэ байна. Гэсэн ч Бурханд өргөж чадах мөнгөтэй байгаадаа талархаж байна.

**Тайлбарлагч** Эмэгтэй чин сэтгэлээсээ бэлдсэн хоёр зоосоо өргөлийн хайрцаганд хийв. Эмэгтэйн өргөсөн зоос бол манайхаар 200-300 төгрөгтэй тэнцэх бага хэмжээний мөнгө байлаа.

.....  
Тон тон тон мөнгө унаж байгаа чимээ.

**Тайлбарлагч** Өргөлийн хайрцаганд зоос унаж байгаа чимээг сонссон хүмүүс эмэгтэйд шоолж эхлэв.

**Хүн-1** Бурханд өргөж байгаа мөнгө биздээ? Хэдхэн зоос хийж болж байгаа юм уу?

**Хүн-2** Итгэл багатай хүн байхаа..

**Хүн-1** Би баян болохоороо энэ тэр баян хүн шиг их хэмжээний мөнгө өргөнөө.



99Page

.....



100Page

**Тайлбарлагч** Энэ бүх зүйлийг чимээгүйхэн хараад сууж байсан хүн байлаа.

Тэр бол Есүс. Есүс дагалдачидаа дуудан ингэж хэлэв.

**Есүс** Түрүүлж өргөл өргөсөн баян хүнээс илүү сая өргөсөн эмэгтэйн өргөл хамгийн их нь байлаа.

**Дагалдагч** Есүс ээ, тэр чинь юу гэсэн үг вэ? Баян их хэмжээний мөнгийг өргөлийн хайрцаганд хийсэн байхад тэр эмэгтэй дөнгөж хоёрхон зоос хийсэн шүү дээ.

**Есүс** Тэр баян өөртөө байгаа мөнгөнийхөө өчүүхэн хэсгийг өргөсөн байхад, харин тэр эмэгтэй өөртөө байгаа бүхнээ Бурханд өргөсөн.

.....

**Тайлбарлагч** Бурхан бидний гаднах төрхийг хардаггүй. Өргөл өргөх үед хэдийг өргөсөн бэ? гэдгийг ч хардаггүй. Харин, Бурханд хэр их хайртайг, бид чин сэтгэлээсээ Бурханд өргөж чадаж байгаа эсэхийг л хардаг юм.



101Page